

## МОНГОЛ УЛСЫН СТАНДАРТ

## Ангилалтын код 67.060

Буудайн гурил хадгалалт, тээвэрлэлт. Техникийн ерөнхий шаардлага	MNS .....: 2024
Wheat flour storage and transportation. General technical requirements	

Стандарт, хэмжил зүйн газрын даргын 2024 оны .. дугаар сарын ..-ны өдрийн ..... дугаар тогтоолоор батлав.

Энэхүү стандартыг 2024 оны .. дугаар сарын ..-ны өдрөөс эхлэн мөрдөнө.

## 1 Хамрах хүрээ

1.1 Энэхүү стандарт нь буудайн гурилыг хадгалах, тээвэрлэх шаардлагыг тогтооно.

## 2 Норматив эшлэл

Энэхүү стандартад олон улсын болон Монгол улсын дараах стандартаас эш татсан бөгөөд эдгээр стандартад өөрчлөлт орсон тохиолдолд сүүлчийн албан ёсны эх хэвлэлээс эш татаж хэрэглэнэ. Үүнд:

*MNS 0244:2009, Буудайн гурил. Техникийн ерөнхий шаардлага;*

*MNS SAC RCP 1:2003, Хүнсний эрүүл ахуйн ерөнхий зарчим (Олон улсын зөвлөмж);*

*MNS 5684:2006, Сав, баглаа боодлын материалд агуулагдах, хүнсний бүтээгдэхүүнд шилжиж болзошгүй химийн бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ;*

*MNS SAC 193:2007, Хүнсний бүтээгдэхүүн дэх хорт болон бохирдуулагч бодисын ерөнхий стандарт;*

*MNS 4504:2008, Хүнсний бүтээгдэхүүн дэх хүнд металлын зөвшөөрөгдөх хэмжээ;*

*MNS 5868:2008, Хүнсний бүтээгдэхүүн дэх пестицидийн үлдэгдлийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ;*

*Сан Пин. 2.3.2.1078-01 Эрүүл ахуйн аюулгүйн норм ба дүрэм;*

*MNS 6308:2012, Хүнсний бүтээгдэхүүн дэх бичил биетний аюулгүй байдал болон эрүүл ахуйн шалгуур үзүүлэлтийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ;*

*MNS 6648:2016, Хүнсний бүтээгдэхүүний сав боодлын шошгололтонд тавих шаардлага;*

*MNS 5649:2006, Үр тариа, гурил, будаа тээвэрлэлт. Ангилал. Тээвэрлэлтийн нөхцөл. Ерөнхий шаардлага;*

*Сан Пин. 2.3.2.1078-01 Эрүүл ахуйн аюулгүйн норм ба дүрэм;*

*ГОСТ 25054-22: Стандарты и требования к хранению муки на складе.*

## 3. Нэр томъёо, тодорхойлолт

### 3.1

#### Савласан гурил

Хэрэглээний зориулалтаар нь ангилан “Гурилын шуудай MNS 2515:1994”-ийн шаардлага хангасан шуудай, уутанд 50 кг хүртэл жинтэйгээр жижиглэн савлаж, амсрыг битүүмжилсэн гурил

### **3.2**

#### **Задгай гурил**

Хэрэглээний зориулалтаар нь ангилан хүнсний аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлага хангасан силосонд хадгалсан гурил

### **3.3**

#### **Силос**

Буудайн гурилыг технологийн горимын дагуу хадгалах, хүнсний аюулгүй байдал эрүүл ахуйн шаардлага хангасан тусгай төхөөрөмжөөр тоногдсон байгууламж

### **3.4**

#### **Металл силос**

Буудайн гурил хадгалах бортгон эсхүл олон талт хэлбэртэй, хүнсний зориулалтын хамгаалалтын бүрхүүлтэй зэвэрдэггүй ган, хөнгөн цагаан хийцтэй силос

### **3.5**

#### **Даавуун силос**

Буудайн гурил хадгалах бортгон эсхүл олон талт хэлбэртэй, даавуун хийцтэй силос

### **3.6**

#### **Гурилыг задгайгаар тээвэрлэгч**

Гаднын бохирдолтоос сэргийлсэн битүүмжлэл сайтай, хийн хоолойгоор задгай гурилыг сорох, шахах дамжуулагатай, хүнсний аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлага хангасан, гурилыг задгайгаар тээвэрлэх зориулалтын тээврийн хэрэгсэл

## **4. Техникийн шаардлага**

Буудайн гурилыг хүнсний эрүүл ахуйн шаардлага хангасан агуулах, силос, тээврийн хэрэгсэлээр аюулгүй ажиллагааны дүрмийг баримтлан батлагдсан журмын дагуу хадгалж, тээвэрлэнэ.

### **4.1 Буудайн гурилыг хадгалах шаардлага**

Буудайн гурилыг агаарын солилцоо сайтай, 15°C-иас дээшгүй температуртай, 60%-иас дээшгүй агаарын харьцангуй чийглэгтэй, хортон шавжаар бохирдоогүй, гаднын элдэв өвөрмөц үнэргүй, шороо чийгээс бүрэн хамгаалсан агуулахад савласан гурилыг зориулалтын тавиур дээр эгнүүлэн хурааж эсхүл силост задгайгаар үйлдвэрлэсэн өдрөөс хойш нэг жилээс дээшгүй хугацаагаар хадгална.

#### **4.1.1 Буудайн гурилыг задгайгаар хадгалах шаардлага**

4.1.1.1 Задгайгаар хадгалах буудайн гурилын чийг 15.0%-иас ихгүй байна.


4.1.1.2 Задгай гурилыг зориулалт, ангилалаар нь төрөлжүүлэн хадгална.

4.1.1.3 Гурилыг задгайгаар хадгалах силос нь битүүмжлэл сайтай, гаднын бохирдлоос бүрэн хамгаалагдсан, металл, даавуун хийцтэй, зориулалтын тусгай төхөөрөмжөөр тоноглогдсон, галд тэсвэртэй байна.

- 4.1.1.4 Силосын дамжуулах хийн хоолой нь гаднын бохирдолтоос сэргийлсэн битүүмжлэлтэй, конденсаци үүсэхээс сэргийлсэн төхөөрөмжтэй, барилгын холбогдох стандартын шаардлагыг хангасан байна.
- 4.1.1.5 Силос нь дээд хэсэгтээ гурилын бургилт үүсэхээс сэргийлсэн шүүлтүүртэй, конус хэлбэрийн вибратор гаралттай, силос доторх үлдэгдэл гурилыг шавхах технологитой байна.
- 4.1.1.6 Силосын агааржуулалтын систем нь нэг урсгалтай, агаарын солилцоо хийх шүүлтүүртэй, бүрэн автоматжсан байна.
- 4.1.1.7 Силос нь хуурай аргаар цэвэрлэх системтэй байна.
- 4.1.1.8 Силосын хэмжих төхөөрөмжүүд, дохиололыг эрх бүхий байгууллагаар баталгаажуулсан байна.
- 4.1.1.9 Силосын орчим нь тээврийн хэрэгсэл бүрэн эргэх талбай, зогсох зурвас тэмдэглэсэн хатуу хучилттай замтай байна.
- 4.1.1.10 Силосыг улирал тутам бүрэн суллаж, эрх бүхий мэргэжлийн байгууллагаар ариутгал, халдваргүйжүүлэлтийг гүйцэтгүүлнэ.
- 4.1.1.11 Ариутгал халдваргүйжүүлэлтээс 3 хоногийн дараа шинээр гурил хүлээн авна.

#### **4.1.1 Буудайн савласан гурилыг хадгалах шаардлага**

- 4.1.2.1 Савлаж хадгалах буудайн гурилын чийг 15.5%-иас ихгүй байна.
- 4.1.2.2 Савласан гурилыг зориулалт, ангилалаар нь төрөлжүүлэн хадгална.
- 4.1.2.3 Савласан гурилыг зориулалтын тавиур дээр эгнүүлэн хурааж хадгална. Нэг тавиурын өргөн-1.20 м, урт-1.5 м-ээс багагүй, шалнаас 0.02м зайтай байна.
- 4.1.2.4 Нэг тавиурын хураалтын өндөр 1.2м-ээс ихгүй, хананаас 0.5 м-ээс багагүй, тавиур хоорондын зай 0.5 м-ээс багагүй байна.
- 4.1.2.5 50кг-аар савласан гурилыг нэг эгнээнд 200кг-аар, 7 эгнээ өндөртэй зангидаж хураах ба 7 эгнээнээс илүү хураахыг хориглоно.
- 4.1.2.6 25кг-аар савласан гурилыг нэг эгнээнд 125кг-аар, 12 эгнээ өндөртэй зангидаж хураах ба 12 эгнээнээс илүү хураахыг хориглоно.
- 4.1.2.7 5г-10кг-аар савласан гурилыг нэг эгнээнд 200кг-аар, 7 эгнээ өндөртэй зангидаж хураах ба 7 эгнээнээс илүү хураахыг хориглоно.
- 4.1.2.8 1кг-аар савласан гурилыг нэг эгнээнд 150кг-аар зангидаж хураах ба 7 эгнээнээс илүү хураахыг хориглоно.
- 4.1.2.9 Савласан гурилыг нурахаас сэргийлэн жигд тараан байршуулж, үе хоорондыг зөв зангидаж, агаар чөлөөтэй нэвтрэхээр хураана /зураг/.



Зураг.Савласан гурил хураах загвар

- 4.1.2.10 Хураасан гурилын эгнээ хоорондын зайг савласан гурилыг ачиж буулгах, тээвэрлэхэд хүрэлцэхгүй байдлаар зохион байгуулна.
- 4.1.2.11 Хураасан гурил бүр багцын шошготой байна. Шошгонд гурилын ангилал, үйлдвэрлэсэн огноо, нэгж савласан гурилын хэмжээ, цувралын дугаар, тэмдэглэгээ зэргийг заана.
- 4.1.2.12 Гурилын агуулахыг гаднын үнэр, тоос, нарны тусгал, цацраг гэх мэт бохирдлын эх үүсвэрийн ойролцоо байршуулахыг хориглоно.
- 4.1.2.13 Борлуулалт, гологдол эсхүл буцаалтын гурилыг тус тусад хадгална.

## 4.2 Буудайн гурилыг тээвэрлэх шаардлага

- 4.2.1 Буудайн савласан гурилыг цэвэр, хуурай, гаднын үнэргүй, хортон шавжаар бохирдоогүй, шороо, чийгнээс хамгаалсан бүрхүүлтэй “MNS CAS RCP 1:2003, Хүнсний эрүүл ахуйн ерөнхий зарчим” (олон улсын зөвлөмж) стандартын шаардлага хангасан тээврийн хэрэгслээр тээвэрлэнэ.
- 4.2.2 Буудайн савласан гурилыг “Үр тариа, гурил, будаа тээвэрлэлт. Ангилал. Тээвэрлэлтийн нөхцөл. Ерөнхий шаардлага MNS 5649:2006” стандартын шаардлага хангасан нөхцөлд тээвэрлэнэ.
- 4.2.3 Буудайн гурилыг задгайгаар зориулалтын тээврийн хэрэгсэл (гурил тээвэрлэгч)-ээр тээвэрлэж болно.
- 4.2.4 Зориулалтын тээврийн хэрэгслийн бүхээг нь ус, шороо нэвтэрдэггүй, гаднын бохирдлоос бүрэн хамгаалагдсан, гурил шахах системтэй байна.
- 4.2.5 Зориулалтын тээврийн хэрэгсэлийн хэмжих төхөөрөмжийг эрх бүхий байгууллагаар баталгаажуулсан байна.
- 4.2.6 Буудайн гурилыг хортой, эвгүй үнэртэй, тэсрэмтгий, шатамхай бараа, бүтээгдэхүүнтэй хамт хадгалж, тээвэрлэхийг хориглоно.
- 4.2.7 Автозамаар тээвэрлэх нэгж ачааны жин 30 тн-оос, төмөр замаар тээвэрлэх нэгж ачааны жин 60 тн-оос тус тус ихгүй байна.
- 4.2.8 Буудайн гурилыг тээвэрлэхэд аюулгүй ажиллагааны тогтоосон шаардлагыг баримтална.

**ТӨГСӨВ.**